

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт <ul style="list-style-type: none">• Шийдвэрийн төсөл• Ололт, амжилттай тал• Дутагдалтай сул тал• Шаардлага	

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,

ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЭЛЭЛ

• Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.

• Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.

• 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	ШАРЫН ГОЛ ХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	21/416Р- 2050374
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	УУЛ УУРХАЙ

	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Дархан Уул аймаг, Шарын гол сум, Санжинт баг Шарын гол ХК
	5. Захирлын нэр, утас, цахим хаяг	Б. Мэндсайхан Mendsaikhan@sharyngol.mn
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Амангелди Amangeldi@sharyngol.mn 99010414
1.2	1. Төслийн нэр	Шарын гол нүүрсний уурхай
	1. Төслийн харъяаллын байршил	ДУА, Шарын гол сум
	3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд в. баяжуулах үйлдвэр	1. Чулуун нүүрсний орд 2. Ил уурхай
	4. Төсөл эхэлсэн огноо	1965.04.06
	5. Төсөл хэрэгжих хугацаа	29 жил
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	-
	7. Хаалтын дараах зориулалт	
	8. ТЭЗҮ баталсан огноо	2022
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	1.700.000
	10. Ажилчдын тоо	599
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	1.700.000
	12. Тухайн төсөлд хамраах дэд бүтэц • замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл;	

<ul style="list-style-type: none"> • шатахуун түгээгүүрийн тоо • шатахуун агуулахын агууламжийн хэмжээ • тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт 	<p>ШТС -1</p> <p>2 ш</p> <p>600 ТН</p> <p>Тэсэлгээний агуулахтай</p>
---	--

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	1498А 2037 он 1767.19 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	

3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	
4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2023.03.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2023 он
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2024.10
7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2024.11
8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2024.01
9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах	
10. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	Давхцалтай 60 га талбайг хасалт хийлгэсэн
11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар <ul style="list-style-type: none"> • Үндэсний • Олон улсын 	MNS ISO 450001

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах,

хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.

- урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- эрсдэлийн үед авах арга хэмжээ
- учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
- хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Ажилласан масло 120 тн
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	600 тн хүчин чадалтай түлшний агуулах
	2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Имүүс-30 тн, анфо-30, агуулахад бэлэн байгаа
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал 	100 тн ашигласан масло. Ахуйн хаягдлыг сумын хот тохижуулахдаа гэрээ хийнэ.

	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Гэрээний дагуу төлбөр тооцоо хийнэ.
--	--	-------------------------------------

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	50.0 сая
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	Үйлдвэрлэлийн зардалд тооцно 35.5.0 сая. Тоожилтыг усалгаа хийж дарах
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	35.0 сая
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	4.4 сая
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	Санжин багийн ИНХурлыг хуралдуулж, үйл ажиллагааны тайлан хэрэгжилтийг тайлагнана. 1.0 сая
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1.0 сая

8.	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	Илэрсэн олдворуудыг сумын байцаагчтай хамтран үзлэг хийх. 0.2 сая
9.	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2.6 сая

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл <ol style="list-style-type: none"> 1. Тосгон 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Хог хаягдлын агуулахын байршил 5. Хог хаягдлын далан 6. Химийн бодисын агуулахын байршил 7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 8. Тухайн жилд хуулах хөрс 9. Гадаад, дотоод овоолго 10. Техникийн нөхөн сэргээлтийн талбай 11. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 12. Гүний худгийн байршил 13. Дүйцүүлэн хамгааллын байршил 	

--	--	--

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1.Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах		Тодорхойлсон			
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах		Тодорхойлсон			

<p>6.3.Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуу лах - амьдрах орчинг хомсдуул ах - нөөцийг бууруула х 		Тодорхойлсо н			
<p>6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> - Бохирду улах - тоос 		Тодорхойлсо н			
<p>6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс</p> <ul style="list-style-type: none"> - Хамгаала х - Нүүлгэн шилжүүл эх 		Тодорхойлсо н			

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	3	Тийм		
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3		Тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ 7.4. - Техникийн/ га эзэлхүүн - Биологийн /га	3.6 га 2.9 сая м3 3.6 га	Тийм		
7.5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	2.0 га	Тийм		
7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ				
7.6 Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		Тийм		
7.7 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ				

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

ХЯНАЛТЫН ХУУДАС

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” баганд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
8.1. Хөрс	1	Карьер	4	1.000.000
8.2. Ус	1	Шүүрлийн ус	4	1.000.000
8.3. Амьтан				
8.4. Ургамал				
8.5. Агаар	1	Карьер	4	1.000.000

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол 2

Хүснэгт2. Нөхөн сэргээлтийн ажлын тооцоо13

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах ажилд шаардагдах зардал.....15


Хүснэгт 4. 2021 онд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажил.....18

Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил.....	19
Хүснэгт 6. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд .	32
Хүснэгт 7. Тэрбум мод тарих хөтөлбөр	21
Хүснэгт 8. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд	33
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил	23
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний үзүүлэлтүүд.....	24
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	25
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа.....	44
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын нэгтгэл.....	26

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Шарын голын нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос хойш 215 км, Эрдэнэт хотоос зүүн тийш 175 км, Дархан хотоос зүүн урагш 45 км зайтай Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт оршдог.

“Шарын гол” хувьцаат компаний эзэмшилд байгаа Шарын голын нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь монгол орны нутгийн төв дунд улс төр, эдийн засгийн, соёл шинжлэх ухааны олон улсын өндөр ач холбогдол бүхий нийслэл Улаанбаатар, Дархан хот болон ОХУ - Монгол Улс - БНХАУ-ыг холбосон төмөр зам, авто хөсгийн замын дэргэд байдгаараа чухал ач холбогдолтой.



Зураг 1. Ордын байршлын тойм зураг

№	Уртгар	Өргөрөг	№	Уртгар	Өргөрөг
1	106° 27' 26.2"	49° 15' 31.91"	56	106° 28' 23.17"	49° 13' 28.21"
2	106° 27' 26.2"	49° 15' 14.91"	57	106° 28' 19.81"	49° 13' 30.79"
3	106° 28' 12.21"	49° 15' 14.91"	58	106° 28' 21.91"	49° 13' 33.35"
4	106° 28' 12.21"	49° 14' 42.91"	59	106° 28' 12.58"	49° 13' 36.88"
5	106° 28' 37.21"	49° 14' 42.91"	60	106° 28' 11.15"	49° 13' 36.88"
6	106° 28' 37.21"	49° 14' 15.71"	61	106° 28' 11.15"	49° 13' 37.44"
7	106° 28' 17.82"	49° 14' 15.94"	62	106° 28' 7.14"	49° 13' 38.96"
8	106° 28' 17.71"	49° 14' 11.91"	63	106° 28' 3.58"	49° 13' 40.88"
9	106° 28' 11.2"	49° 14' 11.91"	64	106° 27' 59.74"	49° 13' 40.95"
10	106° 28' 11.2"	49° 13' 36.92"	65	106° 27' 49.76"	49° 13' 43.74"
11	106° 28' 34.2"	49° 13' 36.92"	66	106° 27' 56.93"	49° 13' 49.45"
12	106° 28' 34.2"	49° 13' 5.91"	67	106° 28' 0.71"	49° 13' 50.45"
13	106° 27' 20.2"	49° 13' 5.91"	68	106° 28' 1.16"	49° 13' 51.32"
14	106° 27' 20.2"	49° 12' 34.92"	69	106° 28' 3.4"	49° 13' 51.71"
15	106° 26' 52.31"	49° 12' 34.92"	70	106° 28' 5.84"	49° 13' 52.36"
16	106° 26' 44.67"	49° 12' 36.97"	71	106° 28' 6.65"	49° 13' 53.03"
17	106° 26' 43.41"	49° 12' 36.98"	72	106° 28' 8.65"	49° 13' 55.77"
18	106° 26' 35.56"	49° 12' 34.92"	73	106° 28' 8.61"	49° 13' 58.34"
19	106° 26' 31.2"	49° 12' 34.92"	74	106° 28' 8.85"	49° 13' 59.46"
20	106° 26' 31.2"	49° 13' 6.92"	75	106° 28' 11.16"	49° 14' 0.58"
21	106° 25' 41.2"	49° 13' 6.92"	76	106° 28' 11.16"	49° 14' 4.58"
22	106° 25' 41.2"	49° 12' 34.92"	77	106° 28' 7.78"	49° 14' 4.64"
23	106° 25' 3.2"	49° 12' 34.92"	78	106° 28' 3.77"	49° 14' 1.11"
24	106° 25' 3.2"	49° 13' 8.92"	79	106° 28' 1.11"	49° 13' 55.48"
25	106° 23' 13.2"	49° 13' 8.92"	80	106° 27' 54.66"	49° 13' 53.26"
26	106° 23' 13.21"	49° 13' 41.92"	81	106° 27' 47.39"	49° 13' 47.27"
27	106° 23' 38.21"	49° 13' 41.92"	82	106° 27' 39.26"	49° 13' 45.99"
28	106° 23' 38.21"	49° 14' 13.91"	83	106° 27' 34.43"	49° 13' 43.19"
29	106° 26' 2.21"	49° 14' 13.91"	84	106° 27' 29.28"	49° 13' 46.38"
30	106° 26' 2.21"	49° 14' 4.91"	85	106° 27' 19.51"	49° 13' 44.82"
31	106° 26' 11.2"	49° 14' 4.91"	86	106° 27' 16.89"	49° 13' 45.92"
32	106° 26' 11.2"	49° 13' 54.91"	87	106° 27' 10.2"	49° 13' 45.32"
33	106° 26' 29.86"	49° 13' 54.91"	88	106° 27' 4.78"	49° 13' 42.96"
34	106° 26' 29.85"	49° 13' 54.82"	89	106° 27' 2.99"	49° 13' 44.22"
35	106° 26' 29.67"	49° 13' 54.45"	90	106° 26' 58.86"	49° 13' 43.4"
36	106° 26' 31.35"	49° 13' 50.12"	91	106° 26' 50.13"	49° 13' 44.66"
37	106° 26' 32.54"	49° 13' 46.97"	92	106° 26' 51.13"	49° 13' 47.09"
38	106° 26' 36.61"	49° 13' 43.44"	93	106° 26' 42.93"	49° 13' 49.41"
39	106° 26' 43.41"	49° 13' 43.36"	94	106° 26' 38.41"	49° 13' 47.94"
40	106° 26' 45.93"	49° 13' 41.37"	95	106° 26' 37.15"	49° 13' 49.51"
41	106° 26' 57.38"	49° 13' 39.41"	96	106° 26' 40.8"	49° 13' 51.98"
42	106° 27' 6.75"	49° 13' 39.24"	97	106° 26' 35.44"	49° 13' 58.79"
43	106° 27' 12.71"	49° 13' 40.84"	98	106° 26' 34.21"	49° 13' 59.3"
44	106° 27' 29.33"	49° 13' 41.05"	99	106° 26' 34.21"	49° 14' 13.91"
45	106° 27' 34.47"	49° 13' 38.67"	100	106° 26' 28.2"	49° 14' 13.91"
46	106° 27' 37.1"	49° 13' 38.72"	101	106° 26' 28.2"	49° 14' 44.92"
47	106° 27' 41.82"	49° 13' 42.47"	102	106° 26' 36.21"	49° 14' 44.92"

48	106° 27' 49.96"	49° 13' 39.28"	103	106° 26' 36.21"	49° 15' 6.92"
49	106° 28' 0.95"	49° 13' 36.61"	104	106° 26' 47.21"	49° 15' 6.92"
50	106° 28' 4.07"	49° 13' 34.73"	105	106° 26' 47.21"	49° 15' 16.91"
51	106° 28' 8.51"	49° 13' 34.06"	106	106° 27' 0.2"	49° 15' 16.91"
52	106° 28' 19.5"	49° 13' 23.37"	107	106° 27' 0.2"	49° 15' 28.52"
53	106° 28' 34.08"	49° 13' 23.81"	108	106° 27' 2.22"	49° 15' 28.51"
54	106° 28' 34.08"	49° 13' 27.6"	109	106° 27' 6.4"	49° 15' 31.08"
55	106° 28' 31.24"	49° 13' 28.14"	110	106° 27' 6.4"	49° 15' 31.91"

MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол

Энэ ордыг олборлож эхэлснээс хойш 50 шахам жил болж төвийн районы нийслэл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг эдийн засгийн томоохон хот суурин, аймаг, орон нутгийн энергийн түлшний хэрэгцээг хангаж байдаг юм.

MV-001498 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 1826.18 га хэмжээтэй талбайд /одоогоор 1767.19 га болсон/ ашигт малтмал ашиглахаар 2009 оны 7-р сарын 03-д “Шарын гол” ХХК 30 жилийн хугацаатайгаар авсан байна. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлуудыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Газрын гадарга, усан сүлжээ, цаг уур

Шарын голын нүүрсний орд газар нь Орхон-Сэлэнгийн сав газрын зүүн өмнөд хэсэгт Хан Хэнтийн нурууны салбар уулсын зах хэсэгт 800-1000 метр хүртэл өргөгдсөн ойт хээрийн бүсэд оршино. Ордын орчны уур амьсгал нь хахир хүйтэн өвөл, хавартай, чийглэгдүү сэрүүн зун намартай эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Хүйтэн ба дулааны улирал: Салхины ноёлох чиглэлийг авч үзвэл өвлийн саруудад өмнө чиглэлүүдийн, хаврын саруудад баруун хойноос зүүн хойд, зуны саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн, намрын улиралд баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал 9.7-29 % ноёлж байдаг ба өвөл намар зуны саруудад 2.5-5.0 м/с, хаврын сард 4.3-6.4 м/с байдаг.

Нарны гийгүүлэл уурхайн орчимд жилдээ 2585 цаг байдаг ч түүний хоног сарын хуваарилалт нь нарны өндөр, улирал, үүлшил зэргээс хамаарна. Зуны саруудад 240-270 цаг, өвлийн саруудад 140-190 цагийн гийгүүлэлттэй байдаг. Нүүрсний орд газарт дулаан хүйтний нөхцөл болох жилийн дундаж агаарын температур -0.9°C байдаг бөгөөд хамгийн дулаан 7 дугаар сард 18.8°C , хамгийн хүйтэн 1 дүгээр сард -25°C . Үнэмлэхүй их халуун 39.4°C , үнэмлэхүй хамгийн их хүйтэн -43°C хүрч байжээ. Энэ бүс нутагт жилдээ 260-300 мм хур

тунадас орж байдгийн 90 % гаруй нь зөвхөн дулааны улиралд унана. Агаарын харьцангуй чийгшил нь температурын эсрэг явцтай, жилдээ 66% байдаг нь уг район нь чийглэгдүү гэдгийг харуулж байна. Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их 72-78%, дараагийн их хэмжээ зуны саруудад 56-66%, хавар 39.8-49% байдаг.

Шарын голын нутаг дэвсгэрт хөрсний хөлдөлт гэсэлт нь тухайн жилийн цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалдаг. Хөрсний хөлдөлт дунджаар 10 дугаар сарын 15-наас эхлэн хөрсний гүн рүү хөлдөлт нэвчиж дараа жилийн 5 дугаар сарын 20 хүртэл нийтдээ хөрсний гадарга хавьд 207 хоног хөлдөлттэй байдаг. Хөрсний гэсэлт дунджаар 4 дүгээр сарын 10-наас 6 дугаар сарын 15-ны хооронд явагдана. Хөрсний хөлдөлтийн гүн нь хөрсний чийг, механик бүрэлдэхүүнээс хамаарч шавар шавранцарт 2.7 м, элсэнцэрт 2.9 м, элсэнд 3.4 м, хайрга, хайрганцар хөрсөнд 3.8 м тус тус байх боловч уурхайд үүнээс бага байдаг.

Ус зүй: Нүүрсний уурхайн дэргэдүүр Шарын гол урсдаг бөгөөд энд Шаазгайт, Буянт, Хавчуугийн жижиг голууд цутгадаг. Эдгээр голууд нь тухайн орчны экологи, эдийн засгийн чухал нөлөөтэй. Нүүрсний уурхайн үйл ажиллагаатай холбогдон Шарын голын үндсэн гольдролыг 2 км орчим газар шилжүүлэн урсгасан байна. Шарын гол нь Хэнтийн нурууны салбар уулсаас эх авч 2930 км² талбайгаас усжин 200 орчим км урсаж Орхон голд цутгана. Голын өргөн нь өргөн хэсэгтээ 200-25 м, гүн нь 0.20 - 0.80 м байдаг. Шарын голын тэжээгдлийн эх үүсвэрийн 20 гаруй хувийг хөрсний ус, үлдсэн хувийг хур тундасны ус эзлэх тул усны горимын хэв шинж хаврын шар ус, зуны хур борооны үерийн горимтой голд хамааруулдаг.

Шарын голын усны химийн найрлагын голлох эх сурвалж нь голын сав газрын уулын чулуулаг хөрс юм. Шарын голын ус нь химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн дунд зэргийн эрдэсжилт хатуулагтай усанд хамрагдана.

2.2 Ургамал, амьтны ертөнц

Шарын голын нүүрсний уурхайн эдэлбэр нь уулт - ойт хээрийн бүсэд Хавчуу, Шаазгайт, Шарын голын бэлчир хавийг хамран бэсрэг уулсын хоорондох хөндийд 900-1000 м хүртэлх үнэмлэхүй өндөрт оршино. Энэ орчмын уулс, ухаа гүвээ, талархаг дэнж газраар хар хүрэн хөрс, голын татам, хотос нам газраар нугын ба нугат - намгийн хөрс, нугархаг газрын захаар нугат - хүрэн хөрс, нарс-хус, шинэс-хусан холимог ойд ойн бараан хөрс, түүний эргэн тойронд хар шороон хөрстэй байна.

Амьтан, ургамал: Шарын голын нүүрсний орд газар нь экологи газар зүйн хувьд ойт, уул хээрийн бүслүүр гэж нэрлэж болох өвөрмөц ландшафтыг үүсгэжээ. Уулын энгэр хажуугийн

болон ойт хээрийн бүс ээлжлэн солигдож байдаг. Ой мод нь уулын арын хажуу дагуу ургах ба хээрийн бүс нь уулын өвөр, энгэр бэл, уулс хоорондын хөндий хоолойгоор ажиглагдаж байдаг. Уг нутаг нь Монгол орны хангай бүсийн шинжийг илэрхийлсэн, ургалт харьцангуй шигүү 1м² талбайд ургасан ургамлын тоо 60-100, өндөр нь 4-14 см хооронд хэлбэлзэж байна.

Энд Хангайн хэв шинжийн нам уулсын нийлмэл цэцэгтэн, үетэн, буурцагтнаас гадна холтсон цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн гэх зэрэг ерөнхийдөө түгээмэл байдаг овгууд нэлээд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Шарын голын районы амьтны аймаг баян, төрөл зүйл олонтой төвийн болон ойт хээрийн бүсийн хөхтний бүлгэмдэл, олон зүйлийн туурайтан, махан идэштэн оршдог нутаг юм. Төрөл бүрийн олон наст ургамал, үетнээс шивээт хялгана, хазаар өвс, хиаг, ерхөг, ботууль түүнчлэн агь, бударгана, цахилдаг зэрэг ургамал зонхилж ургана.

2.3 Бүс нутгийн хөгжил, зам харилцаа, дэд бүтэц

Монгол Зөвлөлтийн хайгуулын баг 1958-1960 онд Шарын голын нүүрсний орд газрыг нээж илрүүлэн ашиглалтын нөөцийг тогтоосноор 1961 оны 10-р сарын 17-нд уурхайн тосгоны анхны суурийг тавьж, улмаар 1962 онд Шарын гол хот байгуулагдсан.

Шарын гол сум нь Хэнтийн нурууны салбар Дархан-Уулын өвөрт далайн түвшнээс дээш 920 м өндөрт оршдог, 16060 га нутаг дэвсгэртэй, 8 мянган хүн амтай, 2000 өрхтэй, 16.0 мянган толгой мал бүхий 1600 гаруй өрх хөдөө амьдардаг. Шарын гол сум зүүн болон зүүн урд талаараа Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, бусад талаараа Дархан-Уул аймгийн Хонгор сумтай хиллэдэг. Улаанбаатар хотоос 210 км, Дархан-Уул аймгаас 75 км авто замаар холбогдсон, Дархан-Шарын голыг холбосон станц, 109.5 км урттай төмөр зам, 1900 тн дизель түлш, бензин хадгалах нефтийн 4 агуулах бүхий орчин үеийн холбоо мэдээллийн сүлжээнд холбогдсон дэд бүтэц хөгжсөн томоохон суурин юм.

Тус суманд нүүрсний томоохон уурхайнуудын нэг Шарын гол ХК, Дулаан Шарын гол ХК, алт олборлолтын уурхайнууд, худалдаа нийтийн хоолны чиглэлээр үйлчилгээ явуулдаг 130 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд ажиллаж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дотоод овоолгын зарим хэсэгт бохир хөрс болон чулуулгийн өөрийн шаталт явагдаж байдаг хүйтний улиралд утааны хэмжээ нэмэгддэг. “Энверонментал комплайнс” компаниар

хийлгэсэн “Байгаль орчны аудит” –ын дүгнэлт, зөвлөмжийн дагуу агаарын бохирдлыг бууруулах ажлыг 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллана.

3.1 Агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол услан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулж, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байна. Уурхайн замаар зорчих хурдны хязгаарыг тогтоож, зөвхөн уурхайд мөрдөгддөг замын хөдөлгөөний нэмэлт дүрмүүдийг баримтлан ажиллах ба 2024 онд 4 цэгээс улирал болгон агаар, тоосны шинжилгээ хийлгэж ажиллахаар төлөвлөж байна.

Ил уурхайн уурхайлалтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг тэсэлгээ, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг боирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна.

3.2 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулахаас гадна хөрсний хүнд метал, хөрсний био ялмагын шинжилгээ өгч ажиллана. Мөн 5 цэгээс цацрагийн шинжилгээ өгч Дархан - Уул аймгийн Мэргэжлийн хяналтын цацрагийн байцаагчаар дүгнэлт гаргуулан ажиллах төлөвлөгөөтэй байна.

3.2 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

УУРХАЙН ТАЛБАЙН УС ЗАЙЛУУЛАЛТ, ТООЦОО

Гидрогеологийн судалгааг “Шарын гол” ХК-ийн захиалгаар 2011 онд “Мэнхэнтахилга” ХХК –ний гидрогеологич МУ-н зөвлөх инженер гидрогеологийн Б.Баасанжав хийж гүйцэтгэсэн. Шарын голын ордын Шарын голын хэсэгт гидрогеологийн нэг цооног өрөмдөж шавхалтын туршилтын ажлыг хийсэн. Судалгааны хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Маршрутын судалгаа 2. Ил уурхайн баруун хэсэгт хайгуулын цооног өрөмдсөн талбайд чулуулгийн тархалт 3. Усны илэрцийн тэмдэглэл хийсэн.

Шарын голын нүүрсний ил уурхайд орж ирэх хур тунадас, болзошгүй үерийн усны хэмжээ

Олон жилийн дунджаар 260-300 мм хур тунадас унадаг. Хур тунадас нь ихэвчлэн богино хугацаанд аадар борооны хэлбэрээр унах бөгөөд сүүлийн жилүүдэд нийт хур

тунадасны 70-90% нь 8-9-р сард орж байна. Шарын голын цаг уурын станцын сүүлийн 10 жилийн ажиглалтаас үзэхэд жилд аадар бороо 5-12 удаа, 34-50.8 мм-ийн хур тунадас унасан байна. Шарын голын нүүрсний ордын нөөц бодсон талбайн ил уурхайд орж ирэх агаарын хур тунадас, болзошгүй үерийн усны хэмжээг дараахь томъёогоор тодорхойлоно.

$$Q = W/t = 41698,14/24 = 1737.42 \text{ м}^3/\text{цаг}$$

W – Зүүн хэсэгт хоногт орох хур тунадасны хэмжээ (болзошгүй үерээс байж болно). $W = F \cdot h_1 \cdot n = 1395520 \cdot 0.0498 \cdot 0.6 = 41698.14 \text{ м}^3$

F – Зүүн хэсгийн талбай, м^2 $F = 1424 \times 980 = 1395520 \text{ м}^2$

h_1 – Зүүн хэсэгт хоногт буух хамгийн их хур тунадас, м $h_1 = 0.0498 \text{ м}$

n – ил уурхайн талбайн урсцын итгэлцүүр, м. Энэ итгэлцүүр ихэвчлэн 0.6-0.7 учир $n = 0.6$ –аар авна.

t - ил уурхайн усыг тасралтгүй 24 цагаар шавхах, цаг

Уурхайд цуглах энэхүү 1737.14 $\text{м}^3/\text{цаг}$ усыг зумпфанд хуримтлуулан дээр сонгосон насосаар шавхан зайлуулна. Шаардлагатай үед нөөцөд байгаа насосыг ажиллуулна. Зумпфын аргаар ус таталтын ажлыг хийж гүйцэтгэдэг ба ус цуглуулах зумфыг уурхайн ёроолд байрлуулж зумпфэнд цугларсан усыг шахуургын станцаар татаж зайлуулдаг.

Ил уурхайн усны хэрэглээ

Ил уурхайн хэсэгт уурхайн дотоод замын тоос дарах усалгаа болон тоног төхөөрөмжинд шаардлагатай усны хэрэглээ орно. Уурхайн автозамын тоосжилтыг 30 тонн даацтай HOWO маркийн 2 автосамосвалаар усална. Автозамыг ээлж болгон, өдөрт дундажаар 28-30 удаа усална. Зам усалгааны ажлыг жилийн хуурайшилт ихтэй улирлуудад явуулах ба хүйтний улирал болон 90 хоног усалгаа хийгдэхгүй. Зам усалгааны ажилд хоногт дунджаар 1800 тн ус хэрглэхээр төлөвлөсөн.

$$Q_{\text{жил}}^{\text{хөрс}} = M \cdot Q_{\text{зам}}^{\text{хоног}} = 275 \times 1800 \text{ м}^3 = 495.000 \text{ м}^3/\text{жил}$$

Үүнд: M – зам усалгааны ажил хийгдэх хоногийн тоо. $M = 275$ хоног;

$Q_{\text{зам}}^{\text{хоног}}$ – зам услах хоногийн усны хэрэглээ, $\text{м}^3/\text{хоног}$.

ХҮСНЭГТ 43 ИЛ УУРХАЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Ус хангамж	Унд, ахуйн хэрэглээ	метр.куб	28,579	ДШГТӨХК ний төв шугамнаас
	Бусад / авто зам услах,	метр.куб	96,197	Техник шинэчлэл, техник нэмэгдсэнээс замын усалгаа нэмэгдсэн
	нөхөн сэргээлт/ мод, зүлэг услах	Метр/куб	9800	Шавхан зайлуулж буй уснаас ашиглах
	Эргүүлэн ашиглах ус	метр.куб	200.000	Буянтын хөндийн Алтны уурхайд эргүүлэн ашиглах усны хэмжээ
	Усыг шавхан зайлуулах	метр.куб	1.802.636	Голруу шавхан зайлуулах усны хэмжээ
	НИЙТ ХЭРЭГЛЭЭ	метр.куб	2.137.212	2024 он нийт ашиглагдах усны хэмжээ

Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Манай уурхай жилд 2.137.000.мян м3 ус шавхан зайлуулдаг. Шавхан зайлуулж буй уснаас алтны шороонд ордод 2.7 км труба татаж шавхан зайлуулж буй усны 4% эргүүлэн ашиглаж байна . Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Ил уурхайгаас гарах шүүрлийн усыг тоос дарах, зам услах зорилгоор ашиглах төлөвлөгөөтэй байна.

Ус шүүрүүлэх систем: Одоогоор уурхайн карьерын уклон 6,7-оос усыг насосоор татан зайлуулж, уклон 6-аас гарсан усыг далд уурхайн гүнд байрлах хиймэл нуур, мөн Шарын гол уруу шавхаж байна. Уклон 7-оос гарсан шавхалтын усыг алтны уурхайн ус хэрэглээг хангах мөн Шарын гол уруу нийлүүлж байна.



Уурхайн ус зайлуулах, шүүрүүлэх цэгүүдийн байрлал

Гүний уурхайн болон ил уурхайд усыг татан зайлуулахад ЦНС-300/240 насосоор өдрийн 8-12 цагаар ажиллуулдаг. Уурхайн ус шүүрүүлэлтийн байдлыг үйл ажиллагааны рапортаас шүүж, насосны ажилласан цаг хугацаагаар нь тооцоолсон болно.

Уклон 6-ын ус татан зайлуулсан тооцоог уурхайд ажилласан насосны хүчин чадал болон ажилласан цагаар тооцож үзэхэд: Нийт тооцооллоор 153 хоногийн хугацаанд насос 2350.3 цаг ажиллаж Үндэслэн уурхайн талбайгаас жилд $1,674,763.3 \text{ м}^3$ усыг татан зайлуулахаар байна.

Буянтын нүүрсний ордын хувьд олборлолтын явцад Шарын гол болон Буянтын голоос дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаас карьерт нүх сүвшил-грунтын уст бүрдлээс цагт $39,18 \text{ м}^3$ ус шүүрэн орж ирэх байна. Ордыг ашиглахад карьерт орж ирэх газар доорх усыг зайлуулан шүүрүүлэх зорилгоор өнөөгийн практикт тухайн ордын гидрогеологийн нөхцөл, усжилтын зэргээс хамааруулан газрын гадаргаас ба газар доороос хосолсон шүүрүүлэн хатаах аргуудыг хэрэглэнэ.

Гидрогеологийн судалгааны үед 3 цооногт явуулсан сорилын шавхалтаар газар доорх усны химийн найрлагыг тодорхойлуулах зорилгоор цооногуудын уснаас сорьц авсан. Сорьцын үр дүнгээр газар доорх ус нь гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, цэнгэг зөөлөн ус байна. Шинжлүүлсэн бүх үзүүлэлт нь манай улсын ундны усны стандарт MNS-9000:2018-ын шаардлага хангаж байгаа тул унданд хэрэглэхэд тохиромжтой гэж тодорхойлжээ.

Олборлолт явуулах карьерын хананд шүүрэн орж ирж байгаа усыг 2⁰-3⁰-ийн налуутай сувгаар дамжуулан усыг малталтын ёроолын өндөржилтийн доод хэсэгт зумфэнд хуримтлуулна. Зумфэнд хуримтлагдсан усыг хэвтээ ба босоо насосоор соруулж зумфийн болон цооногийн хосолсон аргаар зумфнээс соруулсан усыг тунгаагуураар дамжуулан шүүрүүлэх цооногоос гарах усыг шарын голын гол руу зайлуулна.

Уклон -7 -н ус татан зайлуулсан тооцоог уурхайд ажилласан насосны хүчин чадал болон ажилласан цагаар тооцож үзэхэд:

- Нийт 153 хоногийн хугацаанд ойролцоогоор 97 өдөр нь ус татан зайлуулалт хийсэн ба үлдсэн 56 хоногт ус таталт хийгдэхгүй. Энэ хугацаанд насос 1226.88 цаг ажиллаж, 196,300.8 м ус шавхсан байна. Өөрөөр хэлбэл нийт хугацааны 63.3 хувьд нь ус шавхалт хийсэн байна гэж тооцвол 231.04 өдөр жилд ус шавхалт хийсэн байна.
- Өдөрт насос дунджаар 12.551 цаг ажиллахад 1 цагт 160 м³ ус татан зайлуулах бөгөөд
- Өдөрт 2001.6 м³ усыг татан зайлуулна. Нийт 462,449.6 м³ усыг татан зайлуулна..

Уурхайн хэмжээнд нийт уклон 6,7-ийн нийлбэр ус татан зайлуулалт :

БҮГД: $1,674,763.3 + 462,449.6 = 2,137,212.96$ м³

усыг татан зайлуулсан тооцоо гарсан байна.


Таван талт гэрээний дагуу хийх ажлын төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн эзэмшигч Усны тухай хууль, усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн хийлийн заагтай бүсийг хамгаалах нөхөн сэргээх эрх үүрэгтэй. 2025 оны төлөвлөгөөнд онцгой хамгаалалтын бүс доторх Белаз гүүрнээс – Төмөр замын гүүр хооронд 1970 оны эхээр үүсгэсэн овоолгуудыг түрж хэлбэржүүлж техникийн нөхөн сэргээлт хийнэ. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх бөгөөд бэлчээрийн зориулалттай ургамал царгас, согоовор тарина.

Доорх зураг нь нөхөн сэргээлт хийх талбай



Онцгой хамгаалалтын бүсийн намаг татамтай хөрсөнд болон хуучин эвдэрэлд орсон талбайд хөрсний хүнд металын шинжилгээ хийх бөгөөд хөрсний болон усны шинжилгээг 2-3 удаа дээж авч шинжилгээ хийлгэнэ.



Эрх үүргийн дагуу Онцгой хамгаалалтын бүс Шарын гол дагуу ойр хавийн хог хаягдал мал амьтаны сэг зэмийг цэвэрлэнэ. Улиралд 1 удаа жилд 3-4 удаа цэвэрлэгээ хийнэ Уурхайн нийт ажилчдыг оролцуулж төр захиргааны байгууллагад мэдэгдэж шавь тэмдэгийг сэргээн засварлах ажилууд хийгдэнэ.

3.4 Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ил уурхайн уурхайлалтын явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг тэсэлгээний ажил ихээр хийгдэж, үйл ажиллагаанаас үүссэн тоос шорооны нөлөөгөөр ургамлан нөмрөг устаж, тухайн газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад өртөх зэрэг нөлөөллүүд үүснэ.

Өнгөн хөрсийг хуулах үед тухайн газрын ургамлан нөмрөг, шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болсон байна. Ил уурхайд явцын нөхөн сэргээлтээс илүү уурхайн эцсийн буюу хаалтын нөхөн сэргээлт илүү оновчтой байдаг. Хуулж авсан өнгөн хөрсийг стандартын дагуу овоолго хийн хэлбэржүүлэн хадгалж, явцын нөхөн сэргээлтэнд хэрэглэж байна.

3.5 Хог хаягдлын нөлөөлөл

Аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг салхинд хийсгэхгүй байх зорилгоор сумын хогийн цэгт улирал болгон бульдозер гаргаж хог хаягдлыг булшлах, сум орон нутагтайгаа хамтран ажиллах, Шарын гол сумын ЗДТГазартай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж байна.

2025 ОНД БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1 Нөхөн сэргээлт

Төслийн үйл ажиллагааны явцад эвдрэл, элэгдэлд орсон хөрсийг дахин сэргээхийн тулд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг зайлшгүй хийх техникийн шаардлага тавигддаг. Үүнд:

1. Ашиглалт явагдаж дууссан малталтын хана, мөргөцөг, гадаад овоолгын хажуу зэргийг гулсалт, суулт, эвдрэлээс хамгаалах, нөхөн сэргээх
2. Олборлолт-малталтанд орох, овоолгод дарагдах газрын шимт өнгөн хөрсийг тусад нь хадгалах буюу нөхөн сэргээлтэнд шууд ашиглах. Мөн овоолсон шимт өнгөн хөрсийг салхинд хийсэх, үерийн усанд урсахаас хамгаалах арга хэмжээ авна.
3. Уулын ажлын жил бүрийн төлөвлөгөөнд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцоолон төсөвлөх

4. Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд одоо мөрдөж байгаа стандартын шаардлага, техникийн горим, журмыг баримтлана. Жишээлбэл: Ашигт малтмалыг эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, газар шорооны ажлын үед шимт хөрсийг хуулах, эвдэрсэн газарт хучилт хийх хөрс, эвдэрсэн газрын хажуугийн налуу г.м.
5. Хучаас хөрс, овоолгын догол түүний хажууг инженер геологийн төрөл бүрийн процессоос (гулсалт, суулт, эвдрэл) хамгаалах, овоолгын өндрийг 10 м-ээс ихгүй байлгаж ажиллана.
6. Инженер геологийн төрөл бүрийн процесс (гулсалт, суулт, нуралт, эвдрэл, хэв гажилт) малталтын мөргөцөг, хана, овоолгод үүсч байгаа эсэх тэдгээрт байнгын ажиглалт хийх, урьдчилан сэргийлэх, хамгаалах
7. Уурхайн хажуугийн налууугийн ерөнхий өнцгийг 45° -аас ихгүй, хамгаалалтын тавцангийн өргөнийг 20 м-ээс багагүй байлгах
8. Нуралт, суулт, гулсалт үүссэн хэсгийг тогтоож, хамгаалалтын бүс байгуулж, анхааруулах тэмдэг тавьж, ажил дууссаны дараа машин, тоног төхөөрөмжийг мөргөцгөөс холдуулан байршуулах, Овоолго болон уурхайн амсраар хамгаалалтын далан, шуудуу байгуулах


4.2 Техникийн нөхөн сэргээлт

